

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	12
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	12
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	12
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	13
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3	Менежментийн захидал	14
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	16
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	16
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	17
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	19
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22
5	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт	0

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Ч.АЛТАНХУЯГ ТАНАА

2019.02.25 № 06/309
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ч.Алтанхуяг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс, 2019 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Л.Мөнхцацрал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны

өдрийн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын А-1/79 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь Монгол хүн бүрийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, даатгалын тогтвортой санг бүрдүүлэн, даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий менежментийг хэрэгжүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- Эрүүл мэндийн даатгалын сан бүрдүүлэх, орлого, зарлагын тэнцвэрийг ханган ажиллах, үйл ажиллагаагаа тайлагнах;
- Даатгуулагчийг төлөөлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай тусламж, үйлчилгээний зардлын төлбөр тооцоо хийх гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх;

- Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нь харгалзан сонгон шалгаруулах үйл ажиллагааг энэ хуулийн 14.9.11-д заасан журмын дагуу зохион байгуулах;
- Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрт хяналт тавих, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх талаар зөвлөмж, заавар өгөх;
- Энэ хуулийн 14.9.1, 14.9.8-14.9.11-д заасан асуудлаар санал боловсруулж холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Үндэсний зөвлөлөөр шийдвэрлүүлэх болон хуульд заасан бусад чиг үүрэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эмнэлэгийн тусламж үйлчилгээний тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

УИХ-ын 2017 оны "Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай" 40 дүгээр тогтоол, Засгийн газрын 2017 оны "Агентлаг байгуулах тухай" 344 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны "Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, дүрэм батлах тухай" 03 дугаар тогтоолууд тус тус батлагдсанаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагаа 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс албан ёсоор эхэлсэн байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг

алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь 2018 оноос санхүүгийн тайлан толилуулж байгаа тул Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг баталж, мөрдөөгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд энгийн буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп ХХК-ны Acolous програм” хангамж ашигладаг байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардлын 2* хувиар сонгов.

Нийт зардалыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны завсрын аудитаар эрдсэл өндөр байхаар ажиглагдсан, эхлэлтийн тайлан гаргаж байгаа, газрыг дахин үнэлүүлсэн зэрэг хэд хэдэн шалтгаанаар жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгосонтой холбоотой юм.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны Нийт зардал 5,881,925.48 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 117,638.51 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдэл өндөр гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 14 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

				/мянган төгрөгөөр/
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	637,460.80	
3	Албан шаардлага өгсөн	3	345,727.40	
	Дүн	5	983,188.20	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Хөрөнгийн данстай холбоотой асуудал:

Бараа материалын тодруулга тайлангаар 119,236.3 мянган төгрөгийн бараа материалын орлого, 81,720.4 мянган төгрөгийн зарлага бүртгэж оны эцэст 37,515.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд бараа материалын дэлгэрэнгүй тайлан гаргаж, үлдэгдлийг жилийн эцсийн тооллого хийж баталгаажуулаагүй, анхан шатны баримт бүрдэлгүй байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн "үнэн зөв, бодитой, оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагад танилцуулж албан шаардлага өгөх.

2.8.2.1 Зардлын данстай холбоотой асуудал:

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын урсгал зардлын дансны жилийн эцсийн үлдэгдэл 637,460.8 мянган төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ." гэж заасанд нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан бөгөөд дараах үндэслэлээр хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа албан бичгээр ирүүлсэн. Үүнд:

Үйлчлүүлэгч байгууллагын тайлбар:

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.3.1-т "Төсвийн тухай хуулийн 7.7, 44.6-г үндэслэн төсвийн жил дуусахад Улсын төсвийн байгууллагын зарцуулаагүй дансны үлдэгдлийг Улсын төсвийн дансанд, орон нутгийн төсвийн байгууллагын үлдэгдлийг тухайн орон нутгийн төсвийн дансанд, нийгмийн даатгалын төсвийн байгууллагын зарцуулаагүй дансны үлдэгдлийг нийгмийн даатгалын сангийн төсвийн дансанд оны сүүлийн ажлын өдрийн банк хоорондын сүлжээгээр хамгийн сүүлийн орлого татсаны дараа төрийн сангууд шууд татан төвлөрүүлнэ" гэж заасан.

Тайлбарын үндэслэлийг судлаж, шийдвэрлэсэн нь:

Төрийн сангийн үйл ажиллагааны журам нь Засгийн газрын 2017 оны "Агентлаг байгуулах тухай" 344 дүгээр тогтоолоос өмнө буюу Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн "Журам батлах тухай" 24-р тушаалаар батлагдсан тул үндэслэл болгосон 3 дугаар зүйлийн 3.1-т эрүүл мэндийн даатгалын байгууллагын талаар дурдах боломжгүй юм. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т "Дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна: 16.4.5.агентлагийн дарга тус агентлагийн төсвийн;" гэж заасны дагуу төсвийн шууд захирагч бөгөөд тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь заалтыг хэрэгжүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн 2018 оны урсгал зардлын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Эрүүл мэндийн даатгалын сангийн төрийн сан дахь ерөнхий дансанд татан төвлөрүүлэх акт тогтоохоор шийдвэрлэв.

2.8.1.2 Хөрөнгийн данстай холбоотой асуудал:

Тайлант онд 148,614.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 77,881.3 мянган төгрөгийн тавилга, нийт 226,491.1 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэж заасанд үл нийцэж байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан бөгөөд дараах үндэслэлээр хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа албан бичгээр ирүүлсэн. Үүнд:

Засгийн газрын 2017 оны "Агентлаг байгуулах тухай" 344 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулан 21 аймаг 2 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд ЭМДҮЗ 2018 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан орон тооны дагуу шинээр томилогдсон ажилтнуудын ажиллах нөхцлийг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг хүргэх үйл ажиллагааг яаралтай эхлүүлэх зорилгоор нэн шаардлагтай тавилга, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шууд болон харьцуулалтын аргаар хийж, худалдан авсан, орон нутагт байрлаж буй эрүүл мэндийн тасгийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, тавилга, хөрөнгө оруулалтын зардал нь ЭМДЕГ-аас санхүүжүүлж худалдан авсан болно.

Тайлбарын үндэслэлийг судлаж, шийдвэрлэсэн нь:

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны урсгал зардлын төсвөөс худалдан авсан тавилга тоног төхөөрөмжийн нийт төсөвт өртөг нь Засгийн газрын 2013 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 68-р тогтоолоор баталсан шууд болон харьцуулалтын аргаар худалдан авах барааны төсөвт өртгийн дээд хэмжээ болох 50.0 сая төгрөгөөс хэтэрсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно. 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөх шаардлагыг бий болгосон байна. Мөн Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэсэн хуулийн заалтыг давхар зөрчсөн байна.

Иймд тайлбарыг хүлээн авах үндэслэлгүй гэж үзэн Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журмын Хавсралт 2-ын 3-т заасныг үндэслэн хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2.8.3.1: Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал:

Засгийн газрын 2017 оны "Агентлаг байгуулах тухай" 344 дүгээр тогтоолоор ЭМДЕГ-ын орон тооны дээд хязгаарыг 55 байхаар баталсныг ЭМДҮЗ-ийн 2018 оны 04 дүгээр тогтоолоор үндсэн орон тоог 90, гэрээгээр 49, нийт 139 болгон нэмэгдүүлж баталсан байна. 2018 оны 12 дугаар сарын байдлаар үндсэн 97, гэрээт 49 нийт 149 орон тоогоор ажиллаж байгаа нь Засгийн газрын баталсан дээд хязгаараас 94-р илүү байна. Энэ нь Засгийн газрын 344 дүгээр тогтоол, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэж заасантай зөрчилдөж байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагад танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрөхгүй талаар дараах тайлбар хүргүүлсэн. Үүнд:

Засгийн газрын 2017 оны "Агентлаг байгуулах тухай" 344 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустайгаар Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд шинээр байгуулж, 2018 оны эхнээс шинэ бүтцээр байгуулж, 2018 оны эхнээс шинэ бүтцээр төв болон 21 аймаг, 2 дүүрэг /Багануур, Налайх/-ийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 04 дүгээр тогтоолын дагуу баталсан орон тоог мөрдөж байна. "Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай" хуулийн хүрээнд тус агентлагт 139 орон тоо батлагдсанаас төрийн захиргааны 55 орон тоотой байхаар Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан. Тухайн үед шинэ агентлагийн орон тоог Олон улсын валютын сантай байгуулсан гэрээ, УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолд нийцүүлэн шинээр орон тоо нэмэхгүй, зөвхөн НДЕГ-аас шилжин ирэх төрийн захиргааны албан хаагчдын тоог дээд хязгаар болгон баталсан байдаг. 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж байгаа "Төрийн албаны тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д "хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийн удирдах, гүйцэтгэх, албан тушаал" нь төрийн захиргааны албан тушаал байхаар заасан. Иймд Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн тус агентлагийн төрийн захиргааны орон тоог нэмэгдүүлж 139 болгох тухай асуудлаар Эрүүл мэндийн яам болон Төрийн албаны салбар зөвлөлд албан бичгээр хүсэлт хүргүүлсэн. Мөн Сангийн яаманд орон тооны дээд хязгаарыг нэмэгдүүлэх асуудлаар тайлбар, мэдээлэл хүргэгдсэн болно.

Тайлбарын үндэслэлийг судлаж, шийдвэрлэсэн нь:

1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8-д "Үндэсний зөвлөл дараах эрхтэй: 14.8.1.эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, дүрмийг батлах" гэж заасан нь орон тоог нэмж батлах үндэслэлгүй байна.

2. Засгийн газрын агентлагийн тухай хуулийн 9.1-т "Агентлагийн орон тооны дээд хязгаарыг Засгийн газар,.. батална", 8 дугаар зүйл-Агентлагийн удирдлага 8.3.4-т "..., орон тооны дээд хязгаарт багтаан агентлагийн орон тоо, цалингийн санг тогтоох" гэж тодорхой заасан байна. ЭМДЕГ-ийн 2018 оны батлагдсан төсөвт орон тоо 90 байна. Иймээс дээрх зөрчлийг арилгах, орон тооны дээд хязгаарт орсон өөрчлөлтийг Засгийн газраар батлуулах, хуулийн заалтыг мөрдөж ажиллах албан шаардага өгөхөөр шийдвэрлэв.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2.9.1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын барилгад хамаарах 426.3 м.кв газрыг 13,793.9 мянган төгрөгөөр үнэлж санхүүгийн тайланд тусгажээ. Гэвч газар эзэмших гэрчилгээ, эрх бүхий этгээдийн үнэлгээг нягтлан шалгасан тайлангүй, хөрөнгийн бүртгэлд бүртгэх нөхцөл хангагдаагүй байна.

2.9.2. 2018 оны санхүүгийн тайланд Засгийн газрын 344-р тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 46 тогтоолыг тус тус үндэслэн 1,198,238.9 мянган төгрөгийн (анхны өртгөөр) барилгыг балансаас балансад шилжүүлэн бүртгэсэн байна. Гэвч тус барилгын үл хөдлөх хөрөнгө эзэмших эрх шилжиж ирээгүй, барилгын үнэ тодорхойгүй байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 46-р тогтоол болон хавсралтаарх хөрөнгийн дүн 2,491,765,8 мянган төгрөгөөр зөрүүтэйгээс хөрөнгө хүлээлцэхдээ хавсралтаарх дүн 1.998.238.9 мянган төгрөгөөр хүлээн авчээ.

2.9.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн мэдээллийн систем боловсруулахад 280,000.0 мянган төгрөг, "Цахим жор" мэдээллийн системийг хөгжүүлж, нэвтрүүлэхэд 211,975.9 мянган төгрөг, нийт 491,975.9 мянган төгрөг тус тус зарцуулснаас УСНББОУС 31-ийн дагуу 439,565.7 мянган төгрөгийн өртгийг биет бус хөрөнгөд бүртгэсэн байна.

2.9.4 Эрүүл мэндийн сайдын төсвийн багцаас гемодиализын санхүүжилтийн үлдэгдэл 124,204.5 мянган төгрөгийг авлагт тусган, 2019 оны төсвийн жилд хүлээн авсан байна. Гэрээт эмнэлэгүүдтэй хийсэн тооцоо нийлсэн актаар 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар авлага, өглөгийн тооцоогүй, санхүүжилт болон гүйцэтгэлийг мөнгөн сууриар бүртгэсэн байна. Дээрх асуудлыг 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар эрсдэлтэй асуудалд оруулж, 2018 оны жилийн эцсийн гүйцэтгэлээс, дараа оны гүйцэтгэл рүү хөөн шалгахаар шийдвэрлэв.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 3,870,457.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 3,285,650.24 мянган төгрөг буюу 83.6 хувьтай байгаа нь төсвийн төлөвлөлттэй холбоотой байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт анхан шатны баримтыг бүрдүүлэх талаар өгсөн зөвлөмжийг 90 хувь, хангалттай сайн хэрэгжүүлсэн байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй, анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэл

3.1.1 Илрүүлэлт:

2018 онд гемодиализын эмчилгээг үзүүлэх хувийн хэвшлийн эмнэлэгүүдийг сонгон шалгаруулалтыг төсвийн жил эхэлсний дараа зохион байгуулж, 2 дугаар улирлаас гэрээ байгуулан, он дамнуулан хэрэгжүүлж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн цаглабарт хугацаа, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.5-д "тухайн бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Батлагдсан төсөв хэтрэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сонгон шалгаруулалтыг төсвийн цаглабарт хугацаанд багтааж төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	<u>808,652,625.60</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		637,460,773.60
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		637,460,773.60
3121	Төгрөг		637,460,773.60
31211	Төрийн сангийн харилцах		637,460,773.60
33	АВЛАГА		125,792,496.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		124,500.00
335	Бусад авлага		125,667,996.00
3351	Байгууллагаас авах авлага		125,667,996.00
35	БАРАА МАТЕРИАЛ		45,399,356.00
354	Хангамжийн материал		45,399,356.00
35410	Бичиг хэргийн материал		5,604,820.00
35420	Аж ахуйн материал		13,292,148.00
35430	Сэлбэг хэрэгсэл		2,621,730.00
35440	Түлш, шатах тослох материал		4,950,000.00
35470	Бусад хангамжийн материал		18,930,658.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		<u>2,885,957,127.44</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		2,885,957,127.44
391	Газар		13,793,880.00
392	Биет хөрөнгө		2,443,979,747.11
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,998,238,855.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		-99,959,640.38
39203	Авто-тээврийн хэрэгсэл		196,180,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		-86,802,888.85
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		385,355,105.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		-160,035,850.91
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		297,320,257.40
39208	Хуримтлагдсан элэгдэл		-86,316,090.15
393	Биет бус хөрөнгө		428,183,500.33
39301	Програм хангамж		449,555,668.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-21,372,167.67
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		<u>3,694,609,753.04</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		<u>14,104,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		14,104,000.00
413	Өглөг		14,104,000.00
4136	Бусад өглөг		14,104,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		14,104,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		<u>3,680,505,753.04</u>
51	Засгийн газрын хувь оролцоо		3,680,505,753.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		13,793,880.00
51101	Өмч: - төрийн		13,793,880.00
512	Хуримтлагдсан үр дүн		3,666,711,873.04
51220	Тайлант үеийн үр дүн		3,666,711,873.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		<u>3,694,609,753.04</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		9,412,659,318.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		2,368,850,918.34
120	Нийтлэг татварын бус орлого		2,368,850,918.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		2,364,733,406.34
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		2,364,733,406.34
120009	Бусад орлого		4,117,512.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		7,043,808,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		3,870,457,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		3,870,457,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,173,351,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		173,351,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,000,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		5,745,947,445.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,854,330,741.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,854,330,741.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,702,454,925.00
210101	Үндсэн цалин		1,679,607,578.00
210104	Урамшуулал		22,847,347.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		202,183,066.01
210201	Тэтгэврийн даатгал		135,755,746.97
210202	Тэтгэмжийн даатгал		16,915,318.44
210203	ҮОМШӨ-ний даатгал		13,418,862.00
210204	Ажилгүйдлийн даатгал		3,302,654.00
210205	Эрүүл мэндийн даатгал		32,790,484.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		34,926,040.95
210301	Гэрэл, цахилгаан		15,007,338.00
210302	Түлш, халаалт		15,179,099.00
210303	Цэвэр, бохир ус		3,779,603.95
210304	Байрны түрээс		960,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		112,227,138.83
210401	Бичиг хэрэг		38,817,880.00
210402	Тээвэр, шатахуун		18,410,025.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		27,012,520.83
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		85,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		27,901,713.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		88,886,190.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		39,587,177.00
210604	Урсгал засвар		49,299,013.00
2107	Томилолт, зочны зардал		236,587,692.00
210702	Дотоод албан томилолт		236,587,692.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		199,455,406.61

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		177,330,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		1,823,220.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		2,367,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		17,746,886.61
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		188,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		277,610,281.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		103,453,087.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		13,905,150.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		160,252,044.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,891,616,704.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		2,875,795,504.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		2,875,795,504.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		15,821,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		15,821,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		3,666,711,873.04
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		3,666,711,873.04

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		7,047,925,912.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		4,117,512.00
120	Нийтлэг татварын бус орлого		4,117,512.00
120009	Бусад орлого		4,117,512.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		7,043,808,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		3,870,457,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		3,870,457,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,173,351,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		173,351,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,000,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)		5,732,688,074.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ		5,732,688,074.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,715,403,374.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,218,748,115.01
210101	Үндсэн цалин		763,015,827.01
210102	Нэмэгдэл		197,819,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		108,240,000.00
210104	Урамшуулал		149,672,588.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		135,234,041.00
210201	Тэтгэврийн даатгал		105,845,170.00
210202	Тэтгэмжийн даатгал		4,401,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		3,521,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал		880,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал		20,584,871.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		34,926,040.95
210301	Гэрэл, цахилгаан		15,007,338.00
210302	Түлш, халаалт		15,179,099.00
210303	Цэвэр, бохир ус		3,779,603.95
210304	Байрны түрээс		960,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		103,690,823.44
210401	Бичиг хэрэг		30,128,380.00
210402	Тээвэр, шатахуун		24,107,265.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		27,054,127.44
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		85,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		22,316,051.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		90,137,890.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,627,700.00
210604	Урсгал засвар		88,510,190.00
2107	Томилолт, зочны зардал		235,840,452.00
210702	Дотоод албан томилолт		235,840,452.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		773,540,775.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		743,276,055.00

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ		1,823,220.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		2,367,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		22,573,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		188,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		3,312,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		123,285,237.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		109,380,087.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		13,905,150.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,017,284,700.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		2,875,795,504.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		2,875,795,504.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		15,821,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		15,821,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		125,667,996.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		125,667,996.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		<u>1,315,237,837.60</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		677,777,064.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		677,777,064.00
2200	Дотоод эх үүсвэрээр		677,777,064.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		677,777,064.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		<u>-677,777,064.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		637,460,773.60
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		637,460,773.60

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/ төгрөгөөр /						
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D01	2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	13,793,880.00	00.00	3,666,711,873.04	00.00	3,680,505,753.04
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,793,880.00	00.00	3,666,711,873.04	00.00	3,680,505,753.04

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,870,457,000.00	3,235,650,238.40	634,806,761.6	84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,870,457,000.00	3,235,650,238.40	634,806,761.6	84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,827,635,800.00	3,219,829,038.40	607,806,761.6	84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,337,354,500.00	1,218,748,115.01	118,606,385.0	91
210101	Үндсэн цалин	789,093,900.00	763,015,827.01	26,078,073.0	97
210102	Нэмэгдэл	276,182,900.00	197,819,700.00	78,363,200.0	72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	118,800,000.00	108,240,000.00	10,560,000.0	91
210104	Урамшуулал	153,277,700.00	149,672,588.00	3,605,112.0	98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,482,500.00	135,234,041.00	25,248,459.0	84
210201	Тэтгэврийн даатгал	106,988,400.00	105,845,170.00	1,143,230.0	99
210202	Тэтгэмжийн даатгал	13,373,500.00	4,401,900.00	8,971,600.0	33
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,698,800.00	3,521,700.00	7,177,100.0	33
210204	Ажилгүйдлийн даатгал	2,674,700.00	880,400.00	1,794,300.0	33
210205	Эрүүл мэндийн даатгал	26,747,100.00	20,584,871.00	6,162,229.0	77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	239,264,700.00	33,966,040.95	205,298,659.1	14
210301	Гэрэл, цахилгаан	92,739,800.00	15,007,338.00	77,732,462.0	16
210302	Түлш, халаалт	85,696,100.00	15,179,099.00	70,517,001.0	18
210303	Цэвэр, бохир ус	60,828,800.00	3,779,603.95	57,049,196.1	6
2104	Хангамж, бараа материалын зардал	162,148,400.00	104,917,741.44	57,230,658.6	65
210401	Бичиг хэрэг	28,965,000.00	23,473,530.00	5,491,470.0	81
210402	Тээвэр, шатахуун	32,503,400.00	24,107,265.00	8,396,135.0	74
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000,000.00	27,054,127.44	42,945,872.6	39
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	85,000.00	-85,000.0	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,680,000.00	30,197,819.00	482,181.0	98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	278,142,600.00	224,375,030.00	53,767,570.0	81
210601	Багаж, техник, хэрэгсэл	143,142,600.00	135,864,840.00	7,277,760.0	95
210604	Урсгал засвар	135,000,000.00	88,510,190.00	46,489,810.0	66
2107	Томилолт, зочны зардал	110,000,000.00	84,979,052.00	25,020,948.0	77

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	110,000,000.00	84,979,052.00	25,020,948.0	77
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,361,222,200.00	1,303,788,943.00	57,433,257.0	96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	905,443,900.00	892,001,055.00	13,442,845.0	99
210803	Даатгалын үйлчилгээ	2,276,600.00	1,823,220.00	453,380.0	80
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	8,287,800.00	2,367,300.00	5,920,500.0	29
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	404,275,100.00	404,096,568.00	178,532.0	100
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	938,800.00	188,000.00	750,800.0	20
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	40,000,000.00	3,312,800.00	36,687,200.0	8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	179020900.00	113820075.00	65,200,825.0	64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	179,020,900.00	113,820,075.00	65,200,825.0	64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,821,200.00	15,821,200.00	27,000,000.0	37
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	0.0	0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00	0.0	0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	00.00	0.0	0
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,821,200.00	15,821,200.00	27,000,000.0	37
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,821,200.00	15,821,200.00	0.0	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,000,000.00	00.00	27,000,000.0	0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,870,457,000.00	3,870,457,000.00	0.0	100
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,870,457,000.00	3,870,457,000.00	0.0	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,870,457,000.00	3,870,457,000.00	0.0	100
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.0	0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	637,460,773.60	- 637,460,773.6	0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	90.00	146.00	49.0	162
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	90.00	97.00	7.0	108
650010	Гэрээт ажилтан	00.00	49.00	49.0	0

5 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/178/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар			Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Бараа материалын тодруулга тайлангаар 119,236.3 мянган төгрөгийн бараа материалын орлого, 81,720.4 мянган төгрөгийн зарлага бүртгэж оны эцэст 37,515.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд бараа материалын дэлгэрэнгүй тайлан гаргаж, үлдэгдлийг жилийн эцсийн тооллого хийж баталгаажуулаагүй, анхан шатны баримт бүрдэлгүй байна.	119,236.3	Албан шаардлага өгөх	1.ЭМДЕГ-ын дарга 2.Санхүүгийн албаны дарга 3.Нягтлан бодогч	1.Ч.Алтанхуяг 2.Д.Ууганбаяр 3.Б.Батдаваа
2	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын урсгал зардлын дансны жилийн эцсийн үлдэгдэл 637,460.8 мянган төгрөг байна.	637,460.8	Акт тогтоох	1.ЭМДЕГ-ын дарга 2.Санхүүгийн албаны дарга 3.Нягтлан бодогч	1.Ч.Алтанхуяг 2.Д.Ууганбаяр 3.Б.Батдаваа
3	Тайлант онд 148,614.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 77,881.3 мянган төгрөгийн тавилга, нийт 226,491.1 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн.	226,491.1	Албан шаардлага өгөх	1.ЭМДЕГ-ын дарга 2.Санхүүгийн албаны дарга 3.Нягтлан бодогч	1.Ч.Алтанхуяг 2.Д.Ууганбаяр 3.Б.Батдаваа
4	Засгийн газрын 2017 оны "Агентлаг байгуулах тухай" 344 дүгээр тогтоолоор баталсан орон тооны дээд хязгаарыг зөрчсөн.	-	Албан шаардлага өгөх	1.ЭМДЕГ-ын дарга 2.Санхүүгийн албаны дарга 3.Нягтлан бодогч	1.Ч.Алтанхуяг 2.Д.Ууганбаяр 3.Б.Батдаваа
5	2018 онд гемодиализын эмчилгээг үзүүлэх хувийн хэвшлийн эмнэлэгүүдийг сонгон шалгаруулалтыг төсвийн жил эхэлсний дараа зохион байгуулж, 2 дугаар улирлаас гэрээ байгуулан, он дамнуулан хэрэгжүүлж байна.	-	Зөвлөмж өгөх	1.ЭМДЕГ-ын дарга 2.Санхүүгийн албаны дарга 3.Нягтлан бодогч	1.Ч.Алтанхуяг 2.Д.Ууганбаяр 3.Б.Батдаваа
Нийт дүн		983,188.2			

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The entire page is otherwise blank, with no margins, text, or other markings.

[illegible]